ЭРДЭНЭТ БУЛГАНЫ
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС
Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг
Утас: +976 75957008, Факс: +976 70352623
Вэб: www.edc.mn Цахим шуудан: info@edc.mn
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 249 / 25

БАТЛАВ
ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Б ЭРДЭНЭЦОГТ

ЭРДЭНЭТ БУЛГАН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК ЦАХИЛГААН
ОРХОН АЙМАГ

2025 оны 06 дугаар сарын 16

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1.Хэрэглэгчийн нэр, регистр:	"ОРХОН АЙМАГ ЖАРГАЛАНТ СУМЫН ЗДТГ" РД: 9043861
1.2.Ажил үйлчилгээний зориулалт:	Цэвэрлэх байгууламж
1.3.Техникийн нөхцөл авах объектын байршил:	Орхон аймгийн Жаргалант сумын Улаантолгой баг
1.4.Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1.Кадастрын зураг 2.Тодруулах хуудас 3.Улсын бүртгэлийн гэрчилгээ 4.Техникийн нөхцөл хүсэгчийн 01/515 тоот албан бичиг
1.5.Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.6.Тооцооны бүрэн чадал:	35 кВА

Хоёр. Холболтын цэг

2.1.6/0.4 кВ-ын КТПН-158 дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий щитэнд ачаалалд тохирсон автомат бүхий групп тоноглож шинээр гаргалгаа гарагаж, 3х25+1х54 мм2 хөндлөн огтлолтой СИП кабель шугамтай төмөрбетон тулгуур бүхий 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж цахилгаан эрчим хүч авах.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл

3.1.Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг- Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орсон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажсан байх.

3.2.0.4 кВ-ын щитэнд 63 А-ийн дифференциал автомат болон ЭБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, DTSD-545S маркийн сим карттай, чадал хязгаарлах функцтэй, алсаас тасалж залгах зориулалттай, 3 фазын 100 А- ийн баталгаат бүрэн электрон тоолуурыг тусгай хайрцагт суурилуулах.

3.3.Ажлын зураг төслийг зөвшилцөх шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг ЭБЦТС ТӨХК-аар хянуулсан байх.

Дөрөв. Тусгай заалтууд

4.1.Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн фото зургаар баримтжуулж холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.

4.2.Энэхүү техникийн нөхцөлийн дагуу олгогдсон 35 кВА тооцооны бүрэн чадлыг хэтрүүлэн хэрэглэсэн нь нотлогдвол техникийн нөхцөлийг цуцлах болно.

4.3.Гадны эзэмшлийн 0.4 кВ-ын шугамаас холбогдох тохиолдолд тус шугамын эзэмшигчээс зөвшөөрөл авсан байх.

4.4.Шугам тоноглолын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага ЭБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.

4.5.Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур бүрд НСД, ААД, ТАД- д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

4.6.Хэрэглэгчийн эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг хангагч байгууллагатай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

4.7.Цахилгаан дамжуулах агаарын шугам нь:

4.7.1. Цахилгаан дамжуулах шугам нь 1 кВ хүчдэлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх,

4.7.2. Дамжуулагч нь бүрээстэй байх ба хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох,

4.7.3. ЦДАШ-ын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төсөл боловсруулах шатанд ЭБЦТС ТӨХК-тай зөвшилцөн сонгох,

4.7.4. ЦДАШ-ын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөр бетон байх.

4.8.Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд хэрэглэгчийн өмч хөрөнгөнд ноцтой хохирол учирч болох онцлогтой хэрэглэгч дизель цахилгаан үүсгүүртэй байх ба автомат асаалтын систем болон АВР тэй байна. Уг нөөц эх үүсгүүр нь хүчдэл тасарсан тохиолдолд эргэх хүчдэл орж ирэх боломжгүй байдлаар нэмэлт сэлгэн залгах, салгах бүхий тоноглол тавигдсан байна.

4.9.Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах ЦДАШ, ЦДКШ тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ±10%-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.

4.10.Өөрийн шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг дамжуулан холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх

5.1.Шугамын "Ажлын зураг төсөл"- ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.

5.2.Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.

5.3.Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"- ийн заалтуудыг мөрдлөг болгох.

5.4."Эрчим хүчний тухай хууль"- ийн 29.1.9, 30.1.10-д заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.

5.5."Эрчим хүчний тухай хууль"- ийн 30.1.8- д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторх цахилгаан тоног төхөөрөмждөө байнга үзлэг шалгалт хийх. Хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийх.

5.6."Эрчим хүчний тухай хууль"- ийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

5.7.Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.

5.8.Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгэх.

5.9.Техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасны дараа тус комиссын шийдвэрийг үндэслэн ЦШС-д холбоно.

5.10.Цахилгаан эрчим хүчний тооцоог ЭБЦТС ТӨХК-ийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад

6.1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"- ийн 2.17-д заасан заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

6.2.Уг техникийн нөхцөлөөр ЦЭХ авч үйл ажиллагаа явуулах хүчинтэй хугацаа техникийн нөхцөл олгогдсон өдрөөс эхлэн 1 жил байна.

6.3.Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18- ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"- ийн 2.13, 2.16- д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.

ТЕХНИКИЙН КОМИССЫН ГИШҮҮД:
ТЕХНИКИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.АРИУНБАЯР
БОРЛУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЦОГТ
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР Ч.ЛХАГВАСҮРЭН
ШИНЭ ХОЛБОЛТЫН ИНЖЕНЕР Г.ЗОЛБОО